АШУҮИС-ийн Эрүүл мэндийн эдийн засагч хөтөлбөрийн үнэлгээ

Г.Баярбат[1], Б.Оюунтуяа[3], Э.Батмандуул[1], Х.Сэр-Од[2], А.Пүрэвгэрэл[1], Т.Ариунтуяа[1], Ю.Гантөгс[1], Л.Ундрам[1], П.Цэдэн[1], Л.Мөнх-Эрдэнэ[1]

[1]АШУҮИС, НЭМС, Эрүүл мэндийн бодлогын тэнхим
[2]АШУҮИС, НЭМС, Эпидемиологи, биостатистикийн тэнхим
[3]Улсын хоёрдугаар төв эмнэлэг
Цахим шуудан: Bayarbat.g@mnums.edu.mn, Утас: 99897969

Түлхүүр үг:

Эрүүл мэндийн эдийн засагч
Хөтөлбөр
Сумматив
Үнэлгээ

Товч утга:

Үндэслэл: XXI зуунд Анагаахын боловсрол судлалын салбарт гарсан томоохон дэвшил бол нотолгоонд суурилсан анагаах ухааныг түшиглэн сургуулиуд сургалтаа явуулж эхэлсэн байдаг бөгөөд улмаар энэ нь хамгийн үнэн бодит нотолгоонд суурилсан анагаах ухаан болсон байна. Нотолгоонд суурилсан анагаах ухаан боловсролын арга зүй нь тухайн анагаах ухааны мэдлэг мэдээлэл сайн, муу эсэхийг эс харгалзан нотолгоо дэлгэн тавьдаг. Анагаахын боловсролын үнэлгээг үнэн бодит судалгааны үр дүн төдийгүй суралцагчид өөрсдийн хамрагдаж буй сургалтын хөтөлбөрийг хүртээмжтэй байдлыг хэр ойлгож ухаарсанд тулгуурлаж хийнэ. Аливаа сургалтын байгууллага сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд тогтмол үнэлгээ хийж эргэх холбоотой ажиллах нь сургалтын хөтөлбөр амжилттай хэрэгжих нэг үндэс юм[1]. Үнэлгээг 2 зарчмаар явуулдаг ба явцын (форматив) үнэлгээний арга нь оюутны сурах үйл ажиллагаанд туслах тэднийг дэмжих, урамшуулах зорилгоор суралцах явцад нь хийдэг бөгөөд энэ нь эргээд сургалтын үйл ажиллагаанд эргэх холбоотойгоор нөлөөлдөг. Харин төгсгөлийн (сумматив) үнэлгээ нь сургалтын бүтэн мөчлөг явж өнгөрсний дараа оюутны эзэмшсэн мэдлэг, ур чадварын түвшинг тодорхойлох зорилгоор хийж хөтөлбөрийг хэрэгжүүлэх үү? сайжруулах уу? эсвэл зогсоох уу? гэдэгт хариулах зорилгоор үнэлдэг[2]. АШУҮИС-ийн НЭМС-ийн Эрүүл мэндийн боловсролын тэнхим 2000 оноос Эрүүл мэндийн эдийн засагч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Эрүүл мэндийн эдийн засагч мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрт явцын болон төгсгөлийн үнэлгээ хийх, төгсөгчид ажлын байранд гарсны дараа тухайн хөтөлбөрөөр эзэмшсэн мэдлэг, ур чадвар нь ажлын байрны хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлох хэрэгцээ, шаардлага өндөр байна. Мөн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгоход ямар мэдлэг, ур чадвар дутагдаж байгааг тодорхойлох, хөтөлбөрийн агуулгыг ажил олгогчдын хүрээнд хэрэгцээний үнэлгээ хийлгэх, сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг нотолгоонд суурилсан мэдээлэлд тулгуурлан хийх нь үндэслэл болсон. **Зорилго:** Эрүүл мэндийн эдийн засагч мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг үнэлэх. **Арга, аргачлал:** Судалгааг агшингийн судалгааны загвараар хийж гүйцэтгэсэн. Мэргэжилтэн бэлтгэсэн хөтөлбөрт өгсөн сэтгэл ханамж, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлохдоо түүний агуулгыг бүрэн багтаасан асуулгын дагуу төгсөгч болон хамтран ажиллагч эмч, ажил олгогч нараас асуумж судалгаа авсан. Сургалтын сэтгэл ханамжийн талаар оюутан, багш, ажил олгогч, төгсөгчдийн үнэлгээг тооцохдоо лайкерт үнэлгээг ашиглаж (1-5), тойм статистикийн шинжилгээ хийсэн. **Үр дүн:** Судалгаанд 29 байгууллагын хамтран ажиллагч, ажил олгогч нарын нийт 92 удирдах ажилтны төлөөллийг хамруулсан. Эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтнууд тухайн байгууллагад эрүүл мэндийн эдийн засагч шаардлагатай эсэхэд 89.1% нь шаардлагатай гэсэн хариулт өгсөн байна. Эрүүл мэндийн эдийн засагч мэргэжлээр 2006-2017 оны хоорондох төгсөгчид Эрүүл мэндийн эдийн засагч сургалтын хөтөлбөрийг 85% нь дундаас дээш үр дүнтэй гэж үнэлсэн байна. I-IV дамжааны оюутнууд сургалтын үйл ажиллагаанд үнэлэлт өгсөн ба IV дамжааны оюутнуудын 91%, III дамжааны оюутнуудын 89.3%, II дамжааны оюутнуудын 80%, I дамжааны оюутнуудын 87% нь хангалттай гэж үзсэн байна. Мөн хичээл хоорондын уялдаа холбоог I-IV дамжааны оюутнуудын 79% нь дундаас дээш буюу сэтгэл ханамжтай гэж үнэлсэн байна. Эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтнуудаас эрүүл мэндийн эдийн засагч мэргэжлээр төгсөгчдийн сургалтын агуулгын хэрэгцээг үнэлэхэд 77.2% нь өөрчлөлтийн удирдлага, 79.3% нь гүйцэтгэлийн удирдлага, 83.7% нь үйл ажиллагааны удирдлага, санхүүгийн удирдлага, 78.3% нь төслийн менежмент, 87.1% нь төлөвлөлт, 79.3% нь удирдах ажилтны ёсзүй шаардлагатай гэсэн байна. **Дүгнэлт:** Эрүүл мэндийн эдийн засагч бакалаврын сургалтын хөтөлбөрийг үнэлэхэд оюутнуудын сэтгэл ханамжийн түвшин 4.36 ± 0.14, багш нар 4.14±0.66, төгсөгчид 4.11±0.78 дундаас дээш үр дүнтэй гэж үнэлсэн байна. Ажил олгогчид 89.1% нь тухайн байгууллагад эрүүл мэндийн эдийн засагч мэргэжилтэн шаардлагатай гэж үнэлсэн байна.

Үндэслэл: Дэлхийн улс орнуудын хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ сүүлийн гучин жилийн хугацаанд асар их өөрчлөгдөн хөгжиж байна. Эдгээр өөрчлөлтийн үр дүнд Анагаах Ухааны сургуулийг төгсөгчид хурдацтай өөрчлөгдөж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний орчинд үр дүнтэй ажиллах боломжтой болох бөгөөд тус орчинд ажиллах суралцах арга барилыг хайж эрүүл мэндийн боловсрол олгох талаар судалгааг хийх анагаах ухааны боловсрол судлаач нар шаардлагатай байдаг[1].

XXI зуунд Анагаахын боловсрол судлалын салбарт гарсан томоохон дэвшил бол нотолгоонд суурилсан анагаах ухааныг түшиглэн сургуулиуд сургалтаа явуулж эхэлсэн байдаг бөгөөд улмаар энэ нь хамгийн үнэн бодит нотолгоонд суурилсан анагаах ухаан болсон байна. Нотолгоонд суурилсан анагаах ухаан боловсролын арга зүй нь тухайн анагаах ухааны мэдлэг мэдээлэл сайн, муу эсэхийг эс харгалзан нотолгоо дэлгэн тавьдаг[1].

Анагаахын боловсролын үнэлгээг үнэн бодит судалгааны үр дүн төдийгүй суралцагчид өөрсдийн хамрагдаж буй сургалтын хөтөлбөрийг хүртээмжтэй байдлыг хэр ойлгож ухаарсан дээр тулгуурлаж хийнэ[1]. Үнэлгээнд тухайн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар, удирдлагууд, менежерүүд болон хөтөлбөрөөр суралцагчид болон төгсөгчид хамрагдсан байх ёстой байдаг. Америкийн нэгдсэн улс, Канад болон Европын орнуудад анагаахын сургуулиуд нь Дэлхийн Анагаах Ухааны боловсролын Холбоо болон бүс нутгийн Анагаахын боловсролын холбоо болон мэргэжлийн байгууллагуудаас гаргасан хөтөлбөрийн магадлан итгэмжлэх шалгуурын дагуу дотооддоо өөрсдийн үнэлгээгээ тогтмол хийж гарсан үр дүнгийн дагуу хөтөлбөрийн хөгжлийн бодлого, төлөвлөлтөндөө шинэчлэл хийдэг. Гэвч, тус сургуулиудын төгсөгчид, оюутнууд хэрхэн өөрсдийн үнэлгээ хийдэг тухай мэдээ мэдээлэл хомс байдаг.

Аливаа сургалтын байгууллага сургалтын хөтөлбөрийнхөө хэрэгжилтэнд тогтмол үнэлгээ хийж эргэх холбоотой ажиллах нь сургалтын хөтөлбөр амжилттай хэрэгжих нэг үндэс юм. Үнэлгээг 2 зарчмаар явуулдаг ба явцын (форматив) үнэлгээний арга нь оюутны сурах үйл ажиллагаанд туслах тэднийг дэмжих, урамшуулах зорилгоор суралцах явцад нь хийдэг бөгөөд энэ нь эргээд сургалтын үйл ажиллагаанд эргэх холбоотойгоор нөлөөлдөг. Харин төгсгөлийн (сумматив) үнэлгээ нь сургалтын бүтэн мөчлөг явж өнгөрсний дараа оюутны эзэмшсэн мэдлэг, ур чадварын түвшинг тодорхойлох зорилгоор хийж хөтөлбөрийг хэрэгжүүлэх үү? сайжруулах уу? эсвэл зогсоох уу гэдэгт хариулах зорилгоор үнэлдэг[2].

АШУҮИС-ийн НЭМС-ийн хувьд Эрүүл мэндийн эдийн засагч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс хойшхи сургалтын хөтөлбөртөө явцын болон төгсгөлийн үнэлгээ хийх хэрэгцээ шаардлага өндөр байна.

ЭМЭЗ хөтөлбөрөөр төгсөгчид ажлын байранд гарсны дараа тухайн хөтөлбөрөөр эзэмшсэн мэдлэг, ур чадвар нь ажлын байрны хэрэгцээ шаардлагыг хангахад хангалттай байгаа эсэх, цаашид хөтөлбөрийг боловсронгуй болгохын тулд ямар мэдлэг, ур чадвар дутагдаж байгааг тодорхойлж, сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг нотолгоонд суурилсан мэдээлэлд тулгуурлан хийх нь үндэслэл болсон.

Зорилго: "Эрүүл мэндийн эдийн засагч" мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг үнэлэх

Арга, аргачлал: Судалгааг агшингийн судалгааны загвараар хийж гүйцэтгэв. Судалгааг АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны (2022.11.18-ны өдрийн 2022/3-10) зөвшөөрлөөр хийсэн. Сургалтын сэтгэл ханамжийн талаар оюутан, багш, ажил олгогч, төгсөгчдийн үнэлгээг тооцохдоо лайкерт үнэлгээг ашиглаж (1-5) тодорхойлсон.

Судалгааны хамрах хүрээ: Судалгааг АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн Сургуулийн Эрүүл мэндийн эдийн засагч хөтөлбөрөөр хичээллэж байгаа I-IV дамжааны оюутан, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцсон багш нар, Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн эрүүл мэндийн нэгдэл, нэгдсэн эмнэлгүүдэд ажилладаг төгсөгч нар, тус байгууллагуудын удирдах ажилтан, 2000 оноос хойш төгссөн төгсөгчдөөс энгийн зорилготой түүвэрлэлтийн аргыг ашиглан судалгаанд хамруулсан.

Сумматив үнэлгээ нь сургалтын бүтэн цикл явж дууссаны дараа хийгддэг төгсгөлийн үнэлгээ бөгөөд оюутны эзэмшсэн мэдлэг, ур чадварын түвшинг тодорхойлох зорилгоор хийж, түүний найдвартай байдал болон хүчин төгөлдөр байдлыг үнэлдэг. (Зураг 1)



Зураг 1. Хөтөлбөрийн үнэлгээний загвар

Найдвартай байдлын шинжилгээ (Reliability analysis of variable): Судалгааны асуумжийн үнэн зөв буюу найдвартай байдлыг шалгах үүднээс асуумж тус бүрд найдвартай байдлын шинжилгээ хийж cronbach тодорхойлоход 0.70 дээш гарсан учир асуулга оновчтой боловсруулагдсан хэмээн үзээд шинжилгээг цааш үргэлжлүүлэн хийсэн. Хүчин зүйлс тус бүрийн cronbach α –г дараах хүснэгтээр тодорхойлов. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Найдвартай байдлын шинжилгээний үр дүн

№	Асуумж	Асуултын тоо	Асуумжийн найдвартай байдал
1	Суралцагч	68	0.961
2	Төгсөгч	18	0.948
3	Багш	18	0.943

Судалгааны статистик боловсруулалт: Статистик үр дүнгийн боловсруулалтыг SPSS 26.0 программ ашиглан тооцсон. Сургалтын талаар оюутан, багш, ажил олгогч, төгсөгчдийн үнэлгээг тооцохдоо тойм статистикийн шинжилгээ хийсэн.

Үр дүн: Судалгаанд хамрагдсан багш нарын хувьд хөтөлбөрт хичээл заадаг нийт 14 багш оролцсон бөгөөд 21.4% (n-3) нь эрүүл мэндийн эдийн засагч, 21.4% (n-3) нь эдийн засагч, 21.4% (n-3) нь хүний их эмч, 35.8% (n-5) нь бусад мэргэжлийн багш нар байна. Төгсөгчдөөс эрүүл мэндийн эдийн засагч мэргэжлээр 2006-2017 оны хоорондох төсгөгчдийг хамруулсан. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Сургалтын үйл ажиллагаанд өгсөн оюутнуудын сэтгэл ханамжийн ерөнхий түвшин (дунджаар)

№	Үзүүлэлт	Дундаж± Стандарт хазайлт	Доод утга	Дээд утга	Стандарт алдаа
1	Сургалт үр дүнтэй сайн	4.24±0.14	3.96	4.52	0.792
2	Сургалтын зохион байгуулалт сайн.	4.18±0.11	3.96	4.41	0.635
3	Хичээл хоорондын агуулгын уялдаа холбоо сайн.	4.15±0.12	3.91	4.39	0.667
4	Лекц, дадлага, семинар, бие даалтын хичээлийн үр өгөөж сайн байсан.	4.12±0.12	3.87	4.37	0.696
5	Лекц дадлагын сургалт хоорондын уялдаа, холбоо сайн.	4.36±0.11	4.13	4.60	0.653
6	Хичээлүүдийн хоорондын уялдаа, холбоо сайн.	4.21±0.12	3.97	4.46	0.696
7	Багш нарын заах арга зүй сайн байсан.	4.61±0.09	4.41	4.82	0.556
8	Хичээл явуулж буй арга зүй тохиромжтой.	4.24±0.12	3.99	4.49	0.708
9	Сургалтаар эзэмшсэн мэдлэг, ур чадвар бодитой, шударга үнэлэгдсэн.	4.58±0.09	4.38	4.77	0.561
10	Өрөө тасалгаа, анги танхим хангалттай сайн.	3.45±0.22	3.91	3.91	1.277
11	Сургалтанд ашиглах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл хангалттай сайн.	3.79±0.14	3.48	4.09	0.857
12	Сургалтанд хэрэглэгдэх ном, сурах бичиг, гарын авлага, ашиглах материал хангалттай.	3.45±0.16	3.11	3.81	0.971
13	Танхимын сургалт тохиромжтой сайн байсан. (лекц, дадлага, семинар)	4.12±0.12	3.86	4.38	0.741
14	Дадлага сургалт сайн явагдаж байна.	4.21±0.14	3.92	4.5	0.821
15	Оюутны сургалтын ачаалал тохиромжтой.	4.45±0.10	4.24	4.67	0.617
16	Хичээлийн хуваарийн зохицуулалт сурахад тохиромжтой сайн байдаг.	4.24±0.15	3.93	4.55	0.867
17	Сургалтанд би хангалттай сайн оролцож чаддаг.	4.06±0.16	3.73	4.39	0.933

Сургалтын үйл ажиллагаанд өгсөн сурталт үр дүнтэй сайн 4.11±0.78 дундаас дээш үр төгсөгчдийн сэтгэл ханамжийн түвшинг үнэлэхэд дүнтэй байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Сургалтын үйл ажиллагаанд өгсөн төгсөгчдийн сэтгэл ханамжийн ерөнхий түвшин (дунджаар)


№	Үзүүлэлт	Дундаж± Стандарт хазайлт	Доод утга	Дээд утга	Стандарт алдаа
1	Сурталт үр дүнтэй сайн	4.11±0.78	3.73	4.47	0.176
2	Сургалтын зохион байгуулалт сайн	4.15±0.87	3.74	4.56	0.196
3	Хичээл хоорондын агуулгын уялдаа холбоо сайн	4.05±0.82	3.66	4.44	0.185
4	Багш нарын заах арга зүй сайн	4.15±0.81	3.77	4.53	0.182
5	Сургалтаар эзэмшсэн мэдлэг, ур чадвар бодитой, шударга үнэлэгдсэн	4.32±0.73	3.96	4.64	0.164
6	Сургалтанд ашиглах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл хангалттай сайн	3.45±0.94	2.96	3.84	0.210
7	Сургалтанд хэрэглэгдэх ном, сурах бичиг, гарын авлаг, ашиглах материал хангалттай	3.55±0.99	3.08	4.02	0.223
8	Оюутны сургалтын ачаалал тохиромжтой	4.35±1.04	3.86	4.84	0.233
9	Сургалтаар эзэмшсэн мэдлэг, ур чадвар ажлын байрны тодорхойлолтонд заасан үүргийг гүйцэтгэхэд хангалттай	3.95±0.99	3.48	4.42	0.223
10	Би АШУҮИС төгсөгчийн ЭМЭЗ хөтөлбөрийн чанарт сэтгэл хангалуун	4.15±0.81	3.77	4.53	0.182
11	ЭМЭЗ мэргэжлээр төгсөгчид тайлан бичих ур чадвар эзэмшсэн байдал	4.65±0.81	4.27	5.03	0.182
12	ЭМЭЗ мэргэжлээр төгсөгчид нь бодлого боловсруулагч, төлөвлөгч байж чаддаг	4.63±0.75	4.25	4.95	0.169
13	ЭМЭЗ мэргэжлээр төгсөгчид нь үр ашигтай хамтрагч, харилцагч байдаг	4.55±0.82	4.11	4.89	0.185
14	ЭМЭЗ мэргэжлээр төгсөгчид нь хяналт үнэлгээ хийх чадвар сайн эзэмшсэн	4.55±0.82	4.16	4.94	0.185
15	ЭМЭЗ төгсөгчид нь төлөвлөх ур чадвар сайн эзэмшсэн байдаг	4.22±0.89	3.78	4.62	0.200
16	ЭМЭЗ мэргэжлээр төгсөгчид нь илтгэх ур чадвар сайн эзэмшсэн байдаг	4.41±0.82	4.02	4.78	0.184
17	ЭМЭЗ төгсөгчид нь шийдвэр гаргах ур чадвар сайн эзэмшсэн байдаг	4.11±0.78	3.73	4.47	0.176

Сургалтын үйл ажиллагаанд өгсөн багш нарын сэтгэл ханамжийн түвшинг үнэлэхэд Эрүүл мэндийн эдийн засагч сургалтын хөтөлбөрийн чанарыг сэтгэл ханамжийн түвшин 4.11±0.78 дундаас дээш үр дүнтэй гэж үнэлсэн байна. (Хүснэгт 4)

Хүснэгт 4. Сургалтын үйл ажиллагаанд багш нарын өгсөн сэтгэл ханамжийн ерөнхий түвшин (дунджаар)

№	Үзүүлэлт	Дундаж± Стандарт хазайлт	Доод утга	Дээд утга	Стандарт алдаа
1	ЭМЭЗ сургалтын хөтөлбөрийн чанар таны бодлоор хэр байна вэ?	4.14±0.66	3.76	4.53	0.177
2	ЭМЭЗ сургалтын хөтөлбөрийн зохион байгуулалт хэр байна вэ?	4.21±0.69	3.81	4.62	0.187
3	ЭМЭЗ сургалтын хөтөлбөрт шинэчлэл хийх талаар таны бодол?	3.57±0.85	3.08	4.06	0.228
4	ЭМЭЗ мэргэжлийн хэрэгцээ шаардлагыг үнэлнэ үү?	3.07±1.49	2.21	3.93	0.399
5	Лекцийн хичээлийн орчин?	3.14±1.46	2.34	3.99	0.390
6	Дадлага хичээлийн орчин?	3.21±0.14	2.36	4.07	0.395
7	Семинарын хичээлийн орчин?	3.18±1.32	2.25	3.75	0.348
8	Дотоодын ном сурах бичиг?	3.14±1.35	2.36	3.92	0.361
9	Гадаадын ном сурах бичиг?	2.86±1.02	2.26	3.45	0.275
10	Оюутны гарын авлага?	3.36±1.21	2.66	4.06	0.325
11	Цахим үйлчилгээний хүртээмж?	2.93±1.38	2.13	3.73	0.370
12	Сургалтын анги танхим хүрэлцээтэй эсэх?	3.07±0.99	2.54	3.65	0.267
13	Анги танхимын тохижилт хангалттай эсэх?	3.04±0.87	2.49	3.51	0.234
14	Хичээл заахад оюутны суурь мэдлэгийн түвшин хэрхэн хангагдсан байдаг вэ?	3.21±0.97	2.65	3.78	0.261
15	Оюутны сурах идэвх чармайлтыг үнэлнэ үү?	3.14±0.94	2.59	3.69	0.254
16	Оюутны бие даан суралцах чадварыг үнэлнэ үү?	3.64±1.00	3.06	4.22	0.269
17	Оюутны харилцааны ур чадварыг үнэлнэ үү?	3.86±0.86	3.36	4.36	0.231
18	Оюутны мэдээллийн технологи ашиглах чадварыг үнэлнэ үү?	3.36±0.63	2.99	3.72	0.169
19	Оюутны хандлагыг үнэлнэ үү?	3.71±0.99	3.14	4.29	0.266
20	Оюутнуудын илтгэх ур чадварыг үнэлнэ үү?	3.29±0.91	2.76	3.81	0.244

Ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааг 29 эрүүл мэндийн байгууллагын хүрээнд нийт 92 удирдах ажилтныг хамруулан явуулсан. Тухайн эрүүл мэндийн байгууллагад Эрүүл мэндийн эдийн засагч мэргэжилтний хэрэгцээг үнэлэхэд 89.1% нь шаардлагатай гэсэн байна. (Зураг 2)



Зураг 2. Тухайн байгууллагад эрүүл мэндийн эдийн засагч мэргэжилтэн шаардлагатай эсэхийг тодорхойлсон дүн

Эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтнуудаас эрүүл мэндийн эдийн засагч мэргэжлээр төгсөгчдийн сургалтын агуулгын хэрэгцээг үнэлэхэд 77.2% нь өөрчлөлтийн удирдлага, 79.3% нь гүйцэтгэлийн удирдлага, 83.7% нь үйл ажиллагааны удирдлага, санхүүгийн удирдлага, 78.3% нь төслийн менежмент, 87.1% нь төлөвлөлт, 79.3% нь удирдах ажилтны ёсзүй шаардлагатай гэсэн байна. (Зураг 3)



Зураг 3. Ажил олгогчид эрүүл мэндийн эдийн засагч мэргэжлийн сайжруулах шаардлагатай ур чадваруудыг үнэлсэн байдал.

Хэлцэмж: Бүгд Найрамдах Герман Улсын Аачен их сургуулийн профессор Elke B нарын Анагаах ухааны боловсрол эзэмшсэн шинэ эмч нарыг ажлын байранд хэрхэн бэлдсэн талаар өөрсдийг нь өөрсдөөр нь үнэлүүлсэн судалгааг 2011 онд “BMC Medical Education” сэтгүүлд хэвлүүлсэн байна. Тус судалгаанд 1-2 жил ажиллаж байгаа эмч нараас Ликертийн аргаар өөрөө өөрийгөө үнэлэх байдлаар 15 асуулт бүхий асуумж авахад анагаах ухааны боловсрол, эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага нь ажлын байран дээр

ажиллахад 65.8% нь хангалттай, 34.2% нь хангалтгүй гэж хариулсан байна. Бидний хийгдсэн судалгаанд ерөнхий сэтгэл ханамж үнэлгээ 86.9% нь сэтгэл ханамжтай буюу хангалтай, 13.1% нь сэтгэл ханамжгүй буюу хангалтгүй гэж үнэлсэн байна[8]. Энэ нь бидний судалгааны төгсөгчдийн сэтгэл ханамжийн түвшин 4.11±0.78 дундаас дээш үр дүнтэй нийцсэн байна.

АНУ-ын Техасын их сургуулийн Анагаах ухааны нэгдмэл сургалтын хөтөлбөртөө өөрчлөлт хийхдээ тооны ба чанарын үнэлгээний аргуудыг хослуулан хэрэглэж гарсан үр дүнд дүн шинжилгээ хийсэн байна[9]. Үүний адил бидний судалгаагаа тооны болон чанарын аргуудыг хослуулан хийсэн бөгөөд сэтгэл ханамжийн түвшинд хийгдсэн. Төгсөгчид өөрсдийн төгсөн гарсан сургалтанд дундачаар 4.11±0.78 сэтгэл ханамжтай гэж үнэлсэн.

АНУ-ын Майрландын их сургуулийн судлаач Steven J. Durning, Louis N.Pangaro, Linda L.Lawrence, Donna Waechter, John McManigle, Jeffrey L.Jackson нар тус сургуулийг төгсөн ажиллаж буй төгсөгчдийн ажил олгогч нараас төгсөгчдийг үнэлүүлсэн судалгаа хийгдсэн байна. Нийтдээ 1247 ажил олгогч нар тус судалгаанд хамрагдсан. Тус судалгаанд эмнэлзүйн дадал ур чадвар, харилцааны ур чадвар, мэдээлэл технологийн ур чадвар, онолын суурь мэдлэг, асуудал шийдвэрлэх ур чадвар, багаар ажиллах ур чадвар зэрэг 18 төрлийн асуумж авсан байна. Мөн судалгааны асуумжийн найдвартай байдлыг cronbach`s alpha –гаар бодож үзсэн нь бидний судалгаатай ижил байна. Эмнэлзүйн дадал ур чадварт 3.96, мэдээлэл технологийн чадварт 3.56, харилцааны ур чадварт 3.95, онолын суурь мэдлэгт 3.77, асуудал шийдвэрлэх чадварт 3.96, багаар ажиллах чадварт 4.17 гэсэн үнэлгээг тус тус өгсөн байна[10].

Бидний хийсэн судалгаатай төстэй асуумжуудаар судалгааг явуулсан нь ажиглагдаж байна. Сургалтаар эзэмшсэн мэдлэг, ур чадвар ажлын байрны тодорхойлолтод заасан үүрэг гүйцэтгэхэд хангалттай 3.95±0.99, Эрүүл мэндийн эдийн засагч мэргэжлээр төгсөгчид нь бодлого боловсруулагч, төлөвлөгч байж чаддаг 4.63±0.75 гэсэн үнэлгээг төгсөгчид өгсөн. Үр дүнгийн хувьд дунджаас дээгүүр байгаа нь ойролцоо үр дүнтэй байгааг илтгэж байна.

Дүгнэлт: Эрүүл мэндийн эдийн засагч бакалаврын сургалтын хөтөлбөрийг үнэлэхэд оюутнууд сэтгэл ханамжийн түвшин 4.36±0.14, багш нар 4.14±0.66, төгсөгчид 4.11±0.78 дундаас дээш үр дүнтэй гэж үнэлсэн байна. Ажил олгогчдын 89.1% нь тухайн байгууллагад Эрүүл мэндийн эдийн засагч мэргэжилтэн шаардлагатай гэж үнэлсэн.

Ном зүй:

1. *Ц.Лхагвасүрэн, Цэрэндагва Д, Дүнгэрдорж Д, "Анагаах ухааны боловсрол судлал", УБ. 2007 х86-87*
2. *Д.Отгонбаяр, "Анагаахын сургалтын нэгдмэл хөтөлбөрийн үнэлгээний зарим асуудалд" Анагаах ухааны докторын зэрэг горилсон бүтээл. УБ. 2017*
3. *Өсөхбаяр.М, Отгонбаяр.Д, Хүний их эмч бэлтгэх сургалтын нэгдмэл хөтөлбөрийн талаарх төгсөгчдийн сэтгэл ханамж, Эрүүл мэндийн шинжлэх ухаан сэтгүүл, УБ. 2015*
4. *Д.Амарсайхан, "Анагаахын сургалтын төлөвлөгөөг боловсронгуй болгох онол арга зүйн зарим асуудалд" Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. УБ. 2003*
5. *Д.Отгонбаяр, Д.Цэрэндагва, "Боловсролын стратеги, Монголын анагаах ухааны боловсролын шинэчлэл" УБ. 2011 х70-82*
6. *Н.Сүмбэрзул, Ш.Оюунбилэг, "Анагаах ухааны боловсрол" УБ. 2001 х68-106*
7. *Д.Даваалхам, С.Батзориг, Биостатистик, УБ. 2010*
8. *Elke B, Ochsmann, Ulrike Zier, Hans Drexler, Klaus Schmid Well prepared for work? Junior doctors' self-assessment after medical education, 2011 Nov 24. DOI: 10.1186/1472-6920-11-99*
9. *Frey AW, Solomon DJ, Lieberman SA, Levine RE. Fitting the means to the ends: One school`s experience with quantitative and qualitative methods in curriculum evaluation during curriculum change Med Educ Online [serial online] 2000;5:9. Available from URL http://www.med-ed-online.org/*
10. *Steven J. Durning, MD, Louis N. Pangaro, MD, Linda L.Lawrence, MD, Donna Waechter, PhD, John McManigle, MD, Jeffrey L.Jackson, MD, MPH: Acad.Med.2005;80:964-968.*
11. *Azadeh Kordestani Moghaddam, Educational impact of assessment on medical students' learning at Tehran University of Medical Sciences: a qualitative study, 2019 Jul 29. doi: 10.1136/bmjopen-2019-031014*
12. *Tobias Raupach, Jamie Brown et. Summative assessments are more powerful drivers of student learning than resource intensive teaching formats DOI: 10.1186/1741-7015-11-61*
13. *The Executive Council of the WFME (1998). International standards in Medical Education: assessment and accreditation of medical schools*
14. *The Executive Council of the WFME (1998). International standards in Medical Education: assessment and accreditation of medical school educational programmes. A WFME position paper. Medical Education. 32 (5) p 549-558*
15. *Mohamad Al, Afif M, Miriam S, Yara M, Rima J and Eveline H: Nurses' evaluation of physicians' non-clinical performance in emergency departments: advantages,disadvantages and lessons learned. BMC Health Serv Res. 2015; 15: 77.*
16. *Lilach E, Robert C: Preparation for clinical practice: a survey of medical students and graduats perceptions of the effectiveness of their medical school curriculum: Med Teach 2006. 28:162-170*

Health economist program assessment of the MNUMS

Bayarbat G[1], Oyuntuya B[3], Batmanduul E[1], Ser-Od Kh[2], Purevgerel A[1], Ariuntuya T[1], Gantugs Yu[1], Undram L[1], Tseden P[1], Munkh-Erdene L[1]

[1]Department of Health Policy, SPH, MNUMS
[2]Department of epidemiology and biostatistics, SPH, MNUMS
[3]Second State Central Hospital Mongolia
E-mail: bayarbat.g@mnums.edu.mn, Tel: +976-99897969

Background: Advances in the medical education and research in the 21st century is that schools have started to conduct their training based on evidence-based medicine, which has become the most authentic evidence-based medicine. Evidence-based medical education methodology presents evidence regardless of whether the medical knowledge is good or bad. The evaluation of medical education will be based not only on the results of actual research, but also on how well the students understand the accessibility of the curriculum they are participating in[1]. Regular evaluation of the implementation of the curriculum by any educational institution is one of the foundations for the successful program implementation. Assessment conducted in two ways, and formative assessment method is done during the learning process in order to support and motivate the students to help them in their learning activities, which has a feedback effect on the learning activities. But the final (summative) assessment is done to determine the level of knowledge and skills acquired by the student after the training has passed and to answer whether to implement, improve or stop the program[2]. In 2000, the Department of Health Policy of SPH of the MNUMS started implementing the health economics program. There is a high need and demand to conduct process and final assessment of the health economics program, and to determine whether the knowledge and skills acquired by the program meet the needs of the workplace after the graduates enter the workplace. Therefore, this research work has chosen in order to determine what knowledge and skills in lack improvement of the program, conduct a needs assessment of the program content in the context of employers, and reform of the program on evidence-based information.

Aim: Assessing health economics program.

Materials and Methods: The study conducted using a cross-sectional study design. In order to determine the satisfaction given to the program prepared by the specialist and the factors affecting it, questionnaires collected from graduates, doctors and employers according to the questionnaire covered its total content. A summary statistical analysis has performed to calculate student, faculty, employer, and graduates ratings of training satisfaction.

Results: A total of 92 executives from 29 organizations and employers included in the study. 89.1% of the management staff of the health care organization asked if the organization needed a health economist. 85% of health economist graduates between 2006 and 2017 rated the health economics program as moderately effective. I-IV students evaluated the learning activities, and 91% of IV students, 89.3% of III students, 80% of II students, and 87% of I students considered it satisfactory. Also, 79% of the students of the I-IV courses evaluated the connection between courses as above average or satisfactory.

Conclusion: Health economist graduates rated the effectiveness of the health economics program as 4.1±0.78, 89.1% of employers asked that graduates need a health economist in their organization. When evaluating the health economist bachelor's program in the context of students studying health economics and teachers implementing the program, the students participating in the research evaluated it as 4.36±0.14 or above average effectiveness. Teachers rated it moderately effective or 4.14±0.66 when evaluating content, management, and organization.

Keywords: Health economists, Programs, Summative, Evaluation